

ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга 0

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-6

-
1. “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 3-6

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
05 дугаар сарын 31-ний өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Г.Ганболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 42 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Т.Аубакир, Д.Батлут, Ж.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар;
Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд.

Нэг. “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх Б.Даваадалай, Хот, хөдөөгийн хөгжлийн бодлогын зөвлөх Э.Мэндсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн газрын ахлах мэргэжилтэн Ц.Амгалан, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, ахлах мэргэжилтэн Б.Эрхэмбаяр, Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэбат, Арьс шир үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал Т.Баярсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар хариулж, тайлбар хийв.

Г.Ганболд: “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 13 минут үргэлжилж, 16 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр 10 цаг 55 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ҮЙЛДВЭРЖИЛГИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ГАНБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
10 цаг 42 минут

**ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Г.Ганболд: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгаж байна. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ирц бүрдсэн тул 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Адьяасүрэн, Ж.Батжаргал, Г.Ганболд, Г.Дамдинням, Н.Наранбаатар, Ц.Туваан, Г.Тэмүүлэн, О.Цогтгэрэл, Ж.Эрдэнэбат нар хүрэлцэн ирж, хуралдааны ирц бүр бүрдсэн байна. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Хэлэлцэх асуудал. “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэл дэмжих арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ асуудлыг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад асуух асуулт саналтай гишүүн байна уу. Байхгүй байна.

Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Я.Содбаатар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Б.Даваадалай Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх, З.Мэндсайхан, Ерөнхийлөгчийн Хот хөдөөгийн хөгжлийн бодлогын зөвлөх, Ц.Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, М.Дондогдорж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, М.Мөнхболд Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга, Ц.Амгалан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн, Б.Эрхэмбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн, В.Болормаа судлаач, доктор, Д.Алтанцэцэг Монголын ноос ноолуурын холбооны гүйцэтгэх захирал, Ч.Эрдэнэбат Монголын ноос ноол ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал, Т.Баярсайхан Арьс шир үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал гэсэн ийм ажлын хэсэг өнөөдрийн хуралдаанд оролцож байна.

“Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Содбаатар танилцуулна. Ажлын хэсгийн 2 номерын микрофон.

Я.Содбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг Монгол улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн

хүрээнд мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг байгальд ээлтэй байдлаар хөгжүүлэх, түүхий эдийн боловсруулалтын түвшнийг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэр технологийн паркийг иж бүрэн нийлүүлэлтийн сүлжээний хамт үе шаттайгаар байгуулах аж үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож үйлдвэрлэл эрхлэх таатай орчныг бүрдүүлэх чиглэлээр тодорхой заалтууд тусгагдсан байдаг.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлснээр уул уурхайн бус экспортын гол бүтээгдэхүүн болох ноос ноолууран боловсруулалтын чадавхыг үе шаттай ахиулж, дотооддоо бүрэн боловсруулснаар нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл экспортын орлогыг нэмэгдүүлэх боломж бүрдэх юм.

Арьс ширний салбарт жилдээ дунджаар 18 сая ширхэг ширэн түүхий эд нөөц бэлдэх боломжтой хэдий ч эдгээрийн 30 хүрэхгүй хувийг нь боловсруулан зах зээлд гаргаж үлдсэн хувийг нь боловсруулах хүчин чадал дутагдалтай байна.

Тухайлбал, 2023 онд дотоодын боловсруулах үйлдвэрүүд 3,3 сая ширхэг арьс ширэнд хагас боловсруулалт, 2,3 сая ширхэг арьс ширэнд гүн боловсруулалт, нийт 5,5 сая ширхгийг боловсруулж, 12,5 сая ширхэг арьс ширийг боловсруулж чадаагүй гэсэн статистик мэдээ байна. Дотоодын боловсруулах үйлдвэрүүдийн хөрөнгийн чадавх сул, арилжааны банкны зээлийн хүү, барьцаа хөрөнгийн шаардлага өндөр, түүхий эдийн зах зээлд гаднын худалдан авагчдын өрсөлдөөн ширүүн, түүхий эдийн чанар муу бэлтгэлийн оновчтой тогтолцоо бүрэн төлөвшөөгүй хууль, эрх зүйн орчин дутагдалтай зэргээс шалтгаалан түүхий эдээ дотооддоо бүрэн боловсруулж чадахгүй, боломжит орлогоо алдсаар байна.

Түүнчлэн үйлдвэрүүдэд нарийн мэргэжлийн хүний нөөц, инженер, техникийн ажилтнуудын хангамж дутмаг, тогтвор суурьшил сул, хүний нөөцийн дутагдалтай байна. Дэлхийн зах зээлд 2023 оны байдлаар 652 тэрбум ам.долларын хувцасны зах зээлийн хэрэглээ байна гэж тооцоо байдаг. Энэ нь 2027 онд 830 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байгаагаас 2 хувийг ноос ноолуурын бүтээгдэхүүн эзэлж байгаа юм. Мөн дэлхий нийтийн чиг хандлага байгальд ээлтэй үйлдвэрлэлд анхаарлаа хандуулах, эко бүтээгдэхүүний эрэлт хэрэглээ 2032 он гэхэд 2 дахин нэмэгдэх төлөвтэй байна. Бидэнд дэлхийн зах зээлийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээ, Монгол Улсын онцлогт суурилсан цагаан алт хэмээх малын гаралтай түүхий эдийн нөөцөө бүрэн ашиглаж, үнэ цэн шингэсэн бүтээгдэхүүн болгохын зэрэгцээ дэлхийн зах зээлд нэвтрүүлэх, дотооддоо нэмүү өртөг бүтээх боломж бүрэн дүүрэн байна.

Иймд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан Цагаан алт үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төслийг хууль, тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан журмын дагуу Засгийн газарт хүргүүлж санал авсан бөгөөд Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд дурдагдсан асуудлыг хүлээн авч төсөлд тусгалаа.

Түүнчлэн тогтоолын төслийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын цахим хуудсанд байршуулан иргэд олон нийтийн санал бодлыг авч, холбогдох мэргэжлийн байгууллагуудын хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Г.Ганболд: Содбаатар даргад баярлалаа. Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүд байвал нэрсээ өгье. Асуух асуулттай гишүүд байван нэрсээ өгье. Байхгүй байна.

Би нэг асуулт асуучихъя. Тогтоолын төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөрт 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилт 70,9 орчим тэрбум төгрөг тусгасан байгаа. Энэ санхүүжилтүүд нь энэ жилийн төсөв дээр ямар байдлаар суусан байна вэ. Энэ тогтоолын төсөл батлагдсанаар 2024 оны улсын төсөвт тусгагдсан аль салбарууд дээр аль яамны төсөв дээр суусан байна вэ гэдгийг асуух гээд байгаа юм. Энэ нь бол нөгөө төсвийн хуультай зөрчил үүсэх ийм шалтгаан нөхцөл байна уу гэдгийг асууя. Хэн хариулах вэ. 2 номерын микрофоныг өгье.

Я.Содбаатар: Ер нь энэ Улсын Их Хурлын тогтоолын төсөл гарснаар Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр нийтдээ 2,2 их наяд төгрөгийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж байгаа гэсэн үг. 2,2 их наяд төгрөгөөс 1,5 их наяд төгрөгийг бол бид нар арилжааны банкнуудад чөлөөт мөнгөн үлдэгдлээр шийдвэрлэнэ гэсэн ийм бодолтой байгаа. Үүний хүүгийн зөрүүг бол жил, жилийн төсөв дээр цаашидаа тавиад явахаар тооцож байгаа. 600, 700-аад тэрбум төгрөгийн асуудлыг бол төсөв дээр тусгаж, жил жилийн төсөв дээр хүүгийн зөрүү, бусад энэ авах арга хэмжээнүүдийн талаар бид нар хийе гэж ингэж төлөвлөсөн. Тогтоолын төсөлд бол нийтдээ бид нар эрх зүйн чиглэлээр юу хийгдэх юм, зохион байгуулалтын чиглэлээр ямар зүйлүүд хийх юм. Үйлдвэрлэл, аж ахуйн нэгжүүдийг хэрхэн дэмжих юм. Ямар арга хэмжээ авах вэ

гэдэг юмнуудыг нэлээн нарийвчилж тодорхой тусгаж өгсөн.

Энэ удаагийн энэ тогтоол гарснаар бол энэ жил бол манай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, холбогдох сайд нарын багц дээр бол таны хэлж байгаа 70-аад тэрбум төгрөгийг бол зохицуулалт хийж оруулах боломжтой гэж ингэж үзэж байгаа. Нэн шаардлагатай гэж үзвэл бид нар наадмын дараа шинэ парламент байгуулагдах үед бол тодорхой хэмжээний төсвийн тодотголын асуудал яригддаг. Төсвийн ерөнхий захирагч нарын шилжилттэй холбоотойгоор. Тийм учраас энэ үед зарим нэг зүйлүүдийг бол төсвийн тодотголын үеэр нэмж янзлах боломж бүрдэнэ гэж харж байгаа юм.

Тийм учраас одоо бол бид нар эхний ээлжид энэ салбарын яамнууд дээр байгаа багцаар байгаа төсвийн хуваарилалтууд дээр энийг зохицуулалт хийгээд ингэж явах боломжтой гэж ингэж үзсэн. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Засгийн газар дээр бас ийм байдлаар ойлголцсон гэж хэлж болно.

Г.Ганболд: Тогтоолын төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүн байна уу. Үг хэлэх гишүүн байхгүй байна.

“Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ техникийнхэн рүү ярь даа. 66,7 хувийн саналаар тогтоолын төсөл дэмжигдлээ.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Нанзаддын Наранбаатар танилцуулна. Тэмүүлэн дарга танилцуулаарай. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн гишүүн танилцуулна.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Их Хурлын гишүүд та бүхэнд баярлалаа.

10.55 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ